

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД ХАМААРАЛ БҮХИЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ
БОЛОН ГАЗРЫН 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(Хот байгуулалт, хөгжлийн газар)

2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

№	ЗОРИЛГО	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖИЛТ
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг сурталчлах</p> <p>Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг дэмжиж ажиллах</p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах, мэдээллийн булан самбар ажиллуулах</p>	<p>Байгууллагын цахим хуудасны www.uda.ub.gov.mn Хууль эрх зүйн буланд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг байршуулан олон нийтэд нээлттэй сурталчлан ажиллав. Мөн Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийн холбоос, болон “Авлигын эсрэг хамтдаа” таныг сонсож байна буланг тогтмол ажиллуулж байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн “Авлигын эсрэг олуулаа нэгдье”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ” зэрэг ТВ шторк, теле зохиомжийг газрын Угтах хэсэгт байршуулсан дэлгэцээр дамжуулан сурталчилав.</p>
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамруулах	Авлигын эсрэг анхан болон давтан сургалтад шинээр томилогдсон болон нийт албан хаагчийг хамруулах	<p>Авлигатай тэмцэх газрын Facebook хуудасны “ЭБАТ Мэдээлэл” хэсгээс цаг үеийн болон сургалт, зохион байгуулалтын бусад арга хэмжээний мэдээллийг тухай бүр авч ажиллав.</p> <p>Авлигатай тэмцэх газрын “Шударга ёс, хөгжил дэвшилд” уриа бүхий Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн зурагт хуудас, 2020 онд шинэчлэн гаргасан “Мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага” цахим гарын авлага зэргийг байгууллагын Facebook хуудсаар дамжуулан албан хаагчдад танилцуулан ажиллав.</p>

3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ</p> <p>Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулсан байдал</p>	<p>Авлигатай тэмцэх газрын 2021 оны 01/14138 дугаартай албан бичиг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 03/798 дугаартай албан бичгээр тус тус ирүүлсэн Авлигын эсрэг үндэсний чуулганд оролцогч, илтгэгчдээс гаргасан зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулж ажиллав.</p> <p>Тайлант хугацаанд зөрчил арилгуулах чиглэлээр Авлигатай тэмцэх газраас албан бичиг ирээгүй байна.</p>
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж ажиллах	Тайлант хугацаанд хот байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой 5 гэрээ байгуулж, бүх гэрээнд Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх МЭДЭГДЭХ хуудсыг гаргуулан авав. Хот байгуулалтын гэрээ, түүний биелэлтийн явцын талаарх мэдээллийг газрын дотоод сүлжээнд тухай бүр байршуулж ажиллав.
5	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	<p>Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу авлигын эсрэг үйл ажиллагаа, шилэн дансны мэдээлэл, үйл ажиллагааны ил тод байдал зэрэг арга хэмжээг байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулах, иргэд олон нийтийг үзэж танилцах боломжоор хангах</p> <p>Авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр шинэ шийдэл, сайн туршлага, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах</p> <p>Удирдлагын шийдвэрийн талаар нээлттэй байршуулах</p>	<p>1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу шилэн дансны холбогдох мэдээллийг заасан хугацаанд байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулан ажиллав.</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдээллийн ил тод байдал болон үйл ажиллагааны ил тод байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа тогтмол байршуулж, тухай бүр нэмэлт өөрчлөлт, баяжилтыг хийж ажиллав.</p> <p>Байгууллагын цахим хуудсанд www.uda.ub.gov.mn 12 төрлийн 120 мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ – 1 - Үйл ажиллагааны төлөвлөгөө – 10 - Санхүүгийн мэдээ – 10 - Мэргэжлийн зөвлөлийн хурлын мэдээ – 38 - Барилгын ажлын зөвшөөлийн гэрчилгээ олгосон мэдээ – 10 - Цаг үеийн мэдээ – 10 - Хүний нөөцийн мэдээ – 6

		Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг нээлттэй тайлагнах	<ul style="list-style-type: none"> - Бүтэц, зохион байгуулалтын мэдээ – 11 - Тендерийн урилга – 2 - Ирсэн, явсан бичгийн мэдээ – 4 - Үйлчилгээний бүрдүүлэх материал – 23 <p>2.Газраас үзүүлж буй 22 нэр төрлийн төрийн үйлчилгээний бүрдүүлэх материал, үйлчилгээний хяналтын хуудасны өөрчлөлт, баяжилтыг тухай бүр хийн Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Драгон, Дунжингарав, Мишээл, Оргил, төвийн үйлчилгээний ажилтнуудыг сургаж, дадлагажуулах, Баянгол, Баянхошуу төвийн үйлчилгээний ажилтнуудыг мэдээ мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулав.</p> <p>Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны судалгааг 2022 оны 01/652 дугаартай албан бичгээр хүргүүлж, газрын цахим хуудсанд тухай бүр байршуулан нээлттэй мэдээлэв. /2 удаа/ Ирсэн, явсан албан бичгийн шийдвэрлэлтийн болон өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн сарын тайланг тухай бүр байршуулан нээлттэй мэдээлэв. /сар бүрийн нийт 6 удаагийн 12 тайлан/</p>
6	Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлж, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож бэхжүүлэх	Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж, e-mongolia.mn системд холбох ажлыг зохион байгуулах	<p>Газраас үзүүлж буй нийт 22 үйлчилгээний 8 нэр төрлийн үйлчилгээг www.eservice.ulaanbaatar.mn, www.e-mongolia.mn цахимаар авах ажлыг иргэн, хуулийн этгээдэд сурталчлан ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Барилга барих хүсэлт, - Барилгын загвар зураг батлах, - Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, - Барилгад хаяг дугаар олгох, - Байр зүйн зураг, - Тэг тэнхлэгийн актыг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх - Инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх - Архивын лавлагаа олгох үйлчилгээ.

	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна.</p>	<p>Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотой төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулах</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” захирамжаар нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж, 1 алба, 9 хэлтэс, 100 орон тоотойгоор батлагдсан. Үүнээс Төрийн захиргааны 90 албан тушаалын 61 албан тушаалын тодорхойлолтоос Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 136, 137 дугаар тогтоолоор баталсан 30 албан тушаалын 21 албан тушаалын тодорхойлолтыг хэвээр үлдээж, 60 албан тушаалын 40 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албан зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 331, 332 дугаар тогтоолоор тус тус батлуулав.</p>
	<p>Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ын хэрэгжилтийг хангана.</p>	<p>“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ын хэрэгжилтийг хангана.</p>	<p>Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ын дагуу Газрын даргын 2022 оны А/35 дугаар тушаалаар Үнэлгээний баг байгуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 9, 10 дугаар хавсралтын дагуу үнэлэх ажлыг зохион байгуулав.</p> <p>Гүйцэтгэлийн тайланг үнэлүүлсэн 83 албан хаагчаас 68 албан хаагчийг “А” буюу “Маш сайн”, 17 албан хаагчийн “В” буюу “Сайн” гэж үнэлэв.</p> <p>Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчид урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэж заасны дагуу нэг улирлыг 40 хүртэл хувиар, эхний хагас жилийг 2 улирлаар тооцож 80 хувиар тооцож, албан хаагч тус бүрийн авсан үнэлгээний хувиар тооцож урамшуулал олгохоор шийдэв.</p>


	<p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ.</p>	<p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх, ёс зүйн зөрчилгүй ажиллах</p>	<p>Тайлант хугацаанд албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхолтой холбоотой өргөдөл, гомдол ирээгүй болно. Албан хаагчийн ёс зүйтэй холбоотой иргэдээс 3 гомдол ирснийг Ёс зүйн зөвлөл, дотоод хяналт шалгалтаар нягтлан 2 гомдолд албан хаагчийн буруутай нь тогтоогдоогүй тул иргэнд зохих журмын дагуу хариу өгсөн. Албан хаагчийн ёс зүйн алдаа гаргасан 1 албан хаагчид Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д заасны дагуу сануулах хариуцлага тооцсон.</p> <p>Иргэдээс болон байгууллагын албан хаагчдын дунд "Санал хүсэлтийн хайрцаг"-аар санал, зөвлөмж, гомдол талархал хүлээн авах 1 сарын аяныг 4 дүгээр сард зохион байгуулсан. Аяны хүрээнд иргэдээс ямар нэгэн санал, гомдол ирээгүй. Харин албан хаагчдаас давхардсан тоогоор 260 гаруй талархлын захидал, бэлэг ирүүлснийг тухайн бүр нэгж, албан хаагчдад хүргүүлж ажиллав.</p> <p>2021 оны 11 дүгээр сард Ёс зүйн зөвлөлөөс гаргасан Зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулж ажилласнаар албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт болон ажлын цаг ашиглалт сайжирсан.</p>
--	--	---	---

Хянасан:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Тайлан гаргасан:

Ахлах мэргэжилтэн



Ч.Бадамханд

Т.Буянжаргал